

БАТЛАВ.
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЗЭНДМАА

2023 оны 03 дугаар сарын 17 өдөр

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

2023 оны 03 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Нэг. Үндэслэл

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь 2021 оны 01 дүгээр сараас 7 газар, 2 хэлтэстэйгээр үйл ажиллагаа эхлүүлж, улсын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус байгууллагын чиг үүргийн нэг гол хэсэг нь эм, эмнэлгийн хэрэгслийн чанарт хяналт тавьж, зах зээл дэх эмийн чанар, аюулгүй байдлыг хангах явдал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяалалд байсан мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчид, эмийн хяналтын лабораторийг 2022 оны 01 дүгээр сараас тус байгууллагад шилжүүлэн, шуурхай удирдлагаар ханган, одоогийн байдлаар 18 аймагт тус бүр нэг, Улаанбаатар хотод 9, нийт 27 улсын байцаагч эмийн чанар, аюулгүй байдлын хяналтыг хийж байна.

Тус байгууллагын чиг үүргийн нэг гол хэсэг нь эмийн сан, эрүүл мэндийн байгууллагуудад “Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2016” стандартын хэрэгжилтийг хангуулах, хянах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх явдал бөгөөд эмийн чанар, аюулгүй байдал, жороор олгох заалттай эмийг шаардлага хангаагүй жороор болон жоргүй олгож буй байдлыг илрүүлэн таслан зогсоох замаар эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, олон улсын түвшинд хүргэхэд ДЭМБ-ын болон бусад улсын ижил төстэй байгууллагын зохицуулалтын баримт бичиг, сайн туршлагыг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд албан хаагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах нэн шаардлагатай байна.

Мөн 2023-2024 онд Монгол улсын эмийн зохицуулалтын үйл ажиллагааг ДЭМБ-ын жишиг тогтоох үнэлгээний аргачлалаар үнэлж түвшин тогтоох ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд албан хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.

Хоёр. Зорилго

Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах, зах зээл дэх хуурамч, чанар стандартын шаардлага хангаагүй хууль бус эмийг илрүүлэх, жороор олгох эмийн олголт, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн жорын стандарт, дэлхий нийтэд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болоод байгаа антибиотикийн хэрэглээ, эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгоор 21 аймгийн эмийн мэргэжилтнүүд, эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч нарт хууль эрх зүйн болон эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын талаарх сүүлийн үеийн мэдээллийг хүргэж, ажлын уялдаа холбоог сайжруулан, чадавхжуулах, газрын албан хаагчдын англи хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сургалтыг үр дүнтэй зохион байгуулахад энэхүү сургалтын зорилго оршлоо.

Гурав. Гарах үр дүн

1. Төв болон орон нутагт ажиллаж буй эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагчид нь эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, жорын стандарт, жороор олгох эмийн олголт, нийгмийн тулгамдсан асуудал болох антибиотикийн хэрэглээний асуудлын хүрээнд баримталж буй бодлого, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэлтэй болно.

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтыг зохион байгуулахад баримтлах заавар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг тодорхой болж, эмийн чанарт тавих хяналт сайжирна.

3. Оролцогчдын Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын талаарх болон хууль, эрх зүйн мэдлэг дээшилж, хамтын ажиллагаа сайжирна.

4. Эмийн чиглэлээр албан хаагчдын англи хэлний сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, сургалтын агуулгын дагуу гарын авлага, видео боловсруулж, түгээх, сургалтын төгсгөлд сургалтын үр дүнг үнэлэх шалгалтыг зохион байгуулж, түвшин ахиулсан байна.

Дөрөв. Оролцогсод

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газрын төв болон орон нутгийн Эм, биобэлдмэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид, 21 аймгийн эмийн мэргэжилтнүүд - Нийт 40 хүн

2. Нийслэлийн 9 дүүргийн эмийн сангийн төлөөлөл. Нийт 600 эм зүйч, эм найруулагч.

3. Эмийн чиглэлээр албан хаагчдын англи хэлний чадавхийг дээшлүүлэх сургалтад Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 11 албан хаагч

Тав. Зохион байгуулагч

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газар, Захиргаа удирдлагын газар

Зургаа. Санхүүжүүлэгч байгууллага

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Долоо. Шаардагдах төсөв

1. Эм, биобэлдмэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч, орон нутгийн эмийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтын төсөв- 25,064,200 төгрөг
2. Нийслэлийн 9 дүүргийн эмийн сангийн төлөөлөлд зориулсан сургалтын төсөв- 7,159,000 төгрөг
3. Нийт 11 албан хаагчийн англи хэлний сургалтын төсөв-27,874,000 төгрөг

Найм. Хугацаа

1. Эм, биобэлдмэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч, орон нутгийн эмийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг 2023 оны 04 дүгээр сард,
2. Нийслэлийн 9 дүүргийн эмийн сангийн төлөөлөлд зориулсан сургалтыг 2023 оны 04 дүгээр сард,
3. Эмийн чиглэлээр албан хаагчдын англи хэлний чадавхийг дээшлүүлэх сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр

Ес. Хөтөлбөр

№	Сэдэв, агуулга	Хугацаа	Мэдээлэл хийх хүний нэр, албан тушаал
Эм, биобэлдмэлийн улсын байцаагчид, орон нутгийн эмийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт			
Нэг дэх өдөр			
1	Бүртгэл	08.50-09.00	Чанарын хяналтын газар
2	Сургалтын нээлт	09.00-09.10	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт	09.10-09.30	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
4	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх мэдээлэл, эрх зүйн орчин	09.30-09.50	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн ажлын хэсэг
5	Эрүүл мэндийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох журам, хууль эрх зүйн зохицуулалт	09.50-10.20	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лиценз зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа
Цайны завсарлага 10.20-10.30			
6	Экспорт, импортын зөвшөөрөл олголт, хууль эрх зүйн зохицуулалт	10.30-10.50	ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар
7	Эмийн харилцан үйлчлэл, гаж нөлөө, тандалтын асуудлаар	10.50-11.10	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй, байдал, тандалт судалгааны газар
8	Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, хангамжийн асуудал	11.10-11.30	ЭЭХХЗГ-ын Эм хангамжийн газар
9	Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн өнөөгийн байдал	11.30-11.50	ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтэс
10	Дотоодын эм үйлдвэрлэлийн өнөөгийн нөхцөл байдал	11.50-12.10	ЭЭХХЗГ-ын Эм үйлдвэрлэлийн хэлтэс
11	Эмийн жор бичилт, зохистой хэрэглээ	12.10-12.30	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй, байдал, тандалт судалгааны газар
Үдийн цай 12.30-13.30			

12	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэдээлэл	13.30-13.50	ЭЭХХЗГ-ын Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн газар
13	Эм шинжлэх лабораторийн мэдээлэл	13.50-14.10	ЭШЛ-ийн эрхлэгч
14	Антибиотикийн зохистой хэрэглээ	14.10-14.40	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй, байдал, тандалт судалгааны газар
15	Эм, БИБ-ий зар сурталчилгааны асуудал	14.40-15.10	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй, байдал, тандалт судалгааны газар
Цайны завсарлага 15.10-15.20			
16	Клиник эм зүйн асуудал	15.20-15.50	АШУҮИС
17	Эмнэлгийн эм зүйн албаны сайн туршлага, мэдээлэл, хяналт шалгалтад анхаарах асуудал	15.50-16.10	Эмнэлгийн эм зүйн албаны төлөөлөл /Монгол-Японы эмнэлгийн эм зүйн албаны дарга/
18	Эмийн биоэквивалент чанар	16.10-16.40	АШУҮИС
19	Гемодиализийн үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын талаар мэдээлэл	16.40-17.00	Д.Чулуунцэцэг, УНТЭ-ийн Бөөрний зөвлөх эмч, МУ-ын гавьяат эмч, Клиникийн профессор, МУ-ын зөвлөх зэргийн эмч, Монголын гемодиализийн холбооны тэргүүн
20	Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт, хадгалалт, чанар, аюулгүй байдлын талаар	17.00-17.20	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Цусны чанар, аюулгүй байдлын алба
Асуулт, хариулт 17.20-17.30			
Хоёрдахь өдөр			
21	Бүртгэл	08.50-09.00	Чанарын хяналтын газар
22	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хадгалалт, түгээлт, хэрэглээ, устгал	09.00-09.30	Д.Энхцэцэг Чанарын хяналтын газрын Эм биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч
23	Уламжлалт эмийн талаар, анхаарах асуудал	09.30-09.50	ЭМЯ-ны Уламжлалт, анагаах ухааны хэлтэс, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн
24	Вакцин, биобэлдмэлийн хадгалалт, хяналтын талаар	09.50-10.10	ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба
25	Бичиг хэргийн стандарт, архивын талаарх мэдээлэл	10.10-10.30	ЭЭХХЗГ-ын Захиргаа, удирдлагын газар
26	Төрийн албан хаагчийн ёс зүй	10.30-10.50	ЭЭХХЗГ-ын Захиргаа, удирдлагын газар
Цайны завсарлага 10.50-11.00			
27	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зарим анхаарах асуудал	11.00-11.40	Салбарын хяналтын газар
28	Зөрчлийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах нийтлэг асуудлууд	11.40-12.30	Нийслэлийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Н.Энхтуяа
Үдийн цай 12.30-13.30			
29	Улсын байцаагчаас зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахад анхаарах зарим асуудал	13.30-14.30	Нийслэлийн Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Г.Сундуй

30	Вакцин, эм биобэлдмэлийн мэргэжилтэн бэлтгэх сургалт, дадлагын талаар мэдээлэл	14.30-14.50	П.Даваацэрэн, Г.Чинчулуун, Ц.Ганчимэг Чанарын хяналтын газрын Эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч
Цайны завсарлага 14.50-15.00			
31	Хяналт шалгалтын 2023 оны төлөвлөлт, анхаарах асуудал	15.00-16.30	Ш.Энхтуяа Чанарын хяналтын газрын дарга
32	Хяналт шалгалтад анхаарах асуудал, санал солилцох	16.30-17.30	Чанарын хяналтын газар, оролцогчид
Сургалтын хаалт			
Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эмийн сангийн төлөөллийг хамруулах сургалт /Нийт 200 хүн/			
Нэг дэх өдөр			
1	Бүртгэл	08.30-09.00	Чанарын хяналтын газар
2	Сургалтын нээлт	09.00-09.10	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт	09.10-09.30	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
4	Эмийн сангийн тайлан, мэдээ	09.30-09.50	НЭМГ-ын мэргэжилтэн
5	Эмийн жор бичилт, зохистой хэрэглээ	09.50-10.10	ЭЭХХЗГ, АШУУИС
Цайны завсарлага 10.10-10.20			
6	Антибиотикийн зохистой хэрэглээ	10.20-10.50	ЭЭХХЗГ, АШУУИС
7	Эмийн гаж нөлөө үнэлэх, мэдээлэх тогтолцоо, эмийн харилцан үйлчлэл	10.50-11.10	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газар
8	Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, анхаарах асуудлууд	11.10-12.00	Чанарын хяналтын газрын улсын /ахлах/ байцаагчид
9	Асуулт, хариулт	12.00-13.00	Оролцогчид
Нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан дүүргийн эмийн сангийн төлөөллийг хамруулах сургалт /Нийт 200 хүн/			
1	Бүртгэл	13.30-14.00	Чанарын хяналтын газар
2	Сургалтын нээлт	14.00-14.10	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт	14.10-14.30	ЭЭХХЗГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Зэндмаа
4	Эмийн сангийн тайлан, мэдээ	14.30-14.50	НЭМГ-ын мэргэжилтэн
5	Эмийн жор бичилт, зохистой хэрэглээ	14.50-15.10	ЭЭХХЗГ, АШУУИС
Цайны завсарлага 15.10-15.20			
6	Антибиотикийн зохистой хэрэглээ	15.20-15.50	ЭЭХХЗГ, АШУУИС
7	Эмийн гаж нөлөө үнэлэх, мэдээлэх тогтолцоо, эмийн харилцан үйлчлэл	15.50-16.10	ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газар
8	Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, анхаарах асуудлууд	16.10-17.00	Чанарын хяналтын газрын улсын /ахлах/ байцаагчид
9	Асуулт, хариулт	17.00-18.00	Оролцогчид
Нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Налайх, Багануур, Баганхангай дүүргийн эмийн сангийн төлөөллийг хамруулах сургалт /Нийт 200 хүн/			
Хоёр дахь өдөр			